



ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫ ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэврэй сумын “Нөрөөт говь” ОНӨААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: **ӨМА-2024/41/НА-СТА-ОНА**

Цахим хуудас:

www.Umnugovi@audit.mn

Өмнөговь аймаг
Даланзадгад сум
2024 он

Өмнөговь дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ц.Өсөхбаяр

Утас: 70533539 Цахим хаяг: Usukhbayarts@audit.gov.mn

Аудитын менежер: Т.Хонгорзул

Утас: 70533552 Цахим хаяг: Khongorzult@audit.gov.mn

Ахлах аудитор: С.Одончимэг

Утас: 70533552 Цахим хаяг: Odonchimegs@audit.gov.mn

Аудит гэрээгээр гүйцэтгэсэн Ирагам аудит ХХК-ийн

гүйцэтгэх захирал: Ц.Ариунжаргал

Утас: 70539911 Цахим хаяг: iragam.audit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn

2024.09.14 № 297
танай _____ -ны № _____ -г

“НӨРӨӨТ ГОВЬ” ОНӨААТҮГ-ЫН
ЗАХИРАЛ Д.МЭНДСАЙХАН ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Сэврэй сумын Нөрөөт говь ОНӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Сэврэй сумын Нөрөөт говь ОНӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар 871.1 мянган төгрөгийн авлага тусгаагүй, 75 м.кв эзэмшлийн газрыг бүртгээгүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс өндөр бөгөөд Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "үнэн зөв байх", 14 дүгээр зүйлийн 14.4.2 "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага" гэсэн заалтуудтай нийцээгүй, санхүүгийн тайлангийн үнэн зөв байх, нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Борлуулалтын өртөг өмнөх оноос 15,714.7 мянган төгрөгөөр өссөн нь эм болон эм хэрэгслийн үнэ нэмэгдсэнтэй холбоотой байна.

Аудитын гол асуудал

Тайлант онд 106,046.9 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 116,535.4 мянган төгрөгийн зардал гарган, 10,488.5 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Бусад асуудлын хэсэг

Эрүүл мэндийн даатгалын сангаас олгох эмийн үнийн хөнгөлөлтийн 879 жор хүлээн авч, 25,445.0 мянган төгрөгийн хөнгөлөлттэй эмийг иргэдэд олгож үйлчилсэн байна.

016020445

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ӨСӨХБАЯР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(төгрөгөөр)

Д/Д	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ХӨРӨНГӨ	-	-
2	Эргэлтийн хөрөнгө	-	-
3	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	527,798.83	136,846.77
4	Дансны авлага	386,409.24	163,676.17
5	Бараа материал	24,253,850.80	20,691,773.33
6	Эргэлтийн хөрөнгийн дүн	25,168,058.87	20,992,296.27
7	Эргэлтийн бус хөрөнгө	-	-
8	Үндсэн хөрөнгө барилга	8,680,145.83	8,902,973.06
9	Биет бус хөрөнгө	760,249.92	437,249.88
10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	9,440,395.75	9,340,222.94
11	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	34,608,454.62	30,332,519.21
12	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	-	-
13	Өр төлбөр	-	-
14	Богино хугацаат өр төлбөр	-	-
15	Татварын өр	803,301.58	2,217,024.46
16	Бусад богино хугацаат өр төлбөр	3,822,172.01	8,620,954.66
17	Богино хугацаат өр төлбөрийн дүн	4,625,473.59	10,837,979.12
18	Өр төлбөрийн нийт дүн	4,625,473.59	10,837,979.12
19	Эздийн өмч	-	-
20	Өмч: а) төрийн	20,773,772.40	20,773,772.40
21	Хуримтлагдсан ашиг (алдагдал)	9,209,208.63	(1,279,232.31)
22	Эздийн өмчийн дүн	29,982,981.03	19,494,540.09
23	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	34,608,454.62	30,332,519.21

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

(төгрөгөөр)

Д/Д	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Борлуулалтын орлого (цэвэр)	81,735,851.99	87,185,551.06
2	Борлуулалтын өртөг	78,276,567.17	93,991,235.45
3	Нийт ашиг	3,459,284.82	(6,805,684.39)
4	Бусад орлого	21,779,884.00	18,861,374.25
5	Ерөнхий ба удирдлагын зардал	15,042,090.00	22,492,511.70
6	Бусад зардал	50,300.00	51,619.10
7	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	10,146,778.82	(10,488,440.94)
8	Орлогын татварын зардал	-	-
9	Татвар дараах ашиг (алдагдал)	10,146,778.82	(10,488,440.94)
10	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	10,146,778.82	(10,488,440.94)

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

(төгрөгөөр)

Д/Д	Үзүүлэлт	Өмч	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2022 оны 12-р сарын 31 -ний үлдэгдэл	20,773,772.40	9,209,208.63	29,982,981.03

2	Тайлант үеийн цэвэр ашиг /алдагдал /	-	(10,488,440.94)	(10,488,440.94)
3	2023 оны 12- р сарын 31-ний үлдэгдэл	20,773,772.40	(1,279,232.31)	19,494,540.09

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(төгрөгөөр)

Д/Д	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
2	Мөнгөн орлогын дүн (+)	111,684,851.55	116,652,610.50
3	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	103,515,735.99	106,046,925.31
4	Бусад мөнгөн орлого	8,169,115.56	10,605,685.19
5	Мөнгөн зарлагын дүн (-)	111,192,228.00	116,273,562.55
6	Ажиллагчдад төлсөн	9,384,482.00	13,564,266.00
7	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	2,830,658.36	3,598,619.57
8	Бараа материалын худалдан авахад төлсөн	-	94,631,651.33
9	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	-	389,090.92
10	Татварын байгууллагад төлсөн	871,616.33	190,686.30
11	Бусад мөнгөн зарлага	50,300.00	51,619.10
12	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	492,623.55	379,047.95
13	Мөнгөн зарлагын дүн (-)	-	770,000.00
14	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн	-	770,000.00
15	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	(770,000.00)
16	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	-	(390,952.05)
17	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	35,175.28	527,798.82
18	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	527,798.83	136,846.77

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

(төгрөгөөр)

Дугаар	Дансны нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
511001	Бараа бүтээгдэхүүн борлуулсны орлого	84,662,000.00	87,185,551.06
521001	Татаас, санхүүжилтийн орлого		18,861,374.25
611001	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	59,394,000.00	93,991,235.48
701013	Элэгдэл, хорогдлын зардал	2,107,200.00	870,172.81
711001	Ажилчдын цалингийн зардал	16,677,600.00	16,594,646.00
711002	ААН-ээс төлсөн НДШ-ийн зардал	2,084,700.00	2,036,930.78
711003	Албан татвар төлбөр хураамж		1,396.00
711005	Бичиг хэргийн зардал		91,500.00
711006	Шуудан холбооны зардал		308,181.80
711007	Мэргэжлийн үйлчилгээний зардал	600,000.00	660,000.00
711011	Ашиглалтын зардал		659,138.83
711017	Тээврийн зардал	120,000.00	650,454.56

711018	Шатахууны зардал		389,090.92
711016	цэвэрлэгээ үйлчилгээний зардал		231,000.00
741006	Банкны үйлчилгээний шимтгэлийн зардал	57,600.00	51,619.10

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 19,389.1 мянган төгрөгийн НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа илэрснээс аудитын явцад 19,389.1 мянган төгрөгийн алдааг залруулсан байна.

Залруулсан алдаа:

НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, НББОУС, “Ангилал” батламж мэдэгдлийг хангахгүй байгаа

Аудитаар нийт 9,149.5 мянган төгрөгийн зөрчил¹ илэрснээс, 871.1 мянган төгрөгийн албан шаардлага тогтоож, 8,278.5 мянган төгрөгийн зөвлөмж өгсөн.

Хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн акт, албан шаардлага байхгүй

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Төлбөрийн хүсэлтэд 6 буюу 19,348.9 мянган төгрөгийн зөрүүтэй баримт хавсаргасан, 1 буюу 40.2 мянган төгрөгийн цахим төлбөрийн баримтыг хавсаргаагүй байна.	1	19,389.1			1	19,389.1	1	19,389.1				
Дүн	1	19,389.1			1	19,389.1	1	19,389.1				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Үндсэн түүхий эд материалын дансны үлдэгдлийг шалгахад Өмнөговь аймгийн Эргэлтийн эмийн сангийн Удирдах зөвлөлийн 2015 оны шийдвэрээр тогтоосон үнийн нэмэгдэлтэй тайлан нь 8,278.5 мянган төгрөгөөр зөрүүтэй байна.	1	8,278.5					1	8,278.5				

Эрүүл мэндийн даатгалын хэлтэстэй тооцоо нийлсэн акт 871.1 мянган төгрөгийг санхүүгийн тайланд авлагаар тусгаагүй байна.	1	871.1			1	871.1						
Тайлант онд сумын Засаг даргын захирамжаар 75 м.кв газрын эзэмших эрхийг шилжүүлэн авсан боловч үндсэн хөрөнгөнд бүртгээгүй байна.	1				1							
Дүн	3	9,149.6			2	871.1	1	8,278.5				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээ 1 буюу 5,690.5 мянган төгрөгийг мэдээлээгүй, 6 мэдээлэл байршуулаагүй байна.	1	5,690.5					1	5,690.5
Дүн	1	5,690.5					1	5,690.5